



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/484

Улаанбаатар хот

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Дээд боловсролын шинэчлэлийн төслийн Удирдах хорооны 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 19/01 тоот тогтоолоор баталсан “Дээд боловсролын шинэчлэлийн төслийн 2019-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө”-ний 1.а.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийг Олон улсын хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын байгууллагаар үнэлүүлсүгэй.

2.Үнэлүүлэхэд шаардагдах зардал болох 41,000,000 /дөчин нэгэн сая/ төгрөгийг Дээд боловсролын шинэчлэлийн төслийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Нансалмаа/-т зөвшөөрсүгэй.

3.Олон улсын чанарын баталгаажуулалтын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын бодлогын газар /Т.Амаржаргалан/-т даалгасугай.

САЙД



Ё.БААТАРБИЛЭГ

0901538